

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ТОВЧ ТҮҮХ

Өлзийт сумын нутагт хүн ардын боловсролыг дээшлүүлэх, соёлын үрийг тарих сургууль, соёлын байгууллагыг бий болгох үйл хэрэг 1921 оны хувьсгалын дараахнаас эхэлжээ. Хэмжээт цаазат Монгол Улсын засгийн газрын шийдвэр ёсоор 1924 оноос аймаг, хошуудад орон нутгийн бага сургуулийг байгуулж эхэлсэн бөгөөд мөн оны 4 сард цэцэрлэг мандал аймгийн Өлзийт уулын хошууны тэнхим нэртэйгээр Илдэн бейлийн хүрээний дэргэд тэнхимийн сургуулийг байгуулан "Номын тэнхим" хэмээн нэрлэжээ. "Номын тэнхим" байгуулхдаа нийт 12 сурагч, нэг багштай байж, анхны багшаар Гунгаа хэмээх хүн багшлан монгол бичиг, дөрвөн аргын тоо зааж эхэлсэн байна. Өлзийт хошууны "номын тэнхи"-ийн анхны 12 сурагчдын нэрийг сийрүүлбэл:

1. Норовжанцан. Нас 14, эцэг ван агсан Дэндэвжанцан урьд бие барсан, эх Цэрэндолгорын хамт байдаг. Сант сумын уугуул.
2. Жанцай. Нас 17, бутач, эх Бадамжавын хамт. Дэлгэрэх сум.
3. Авирмэд. Нас 10. эцэг Снолт, эх Цэрэндулам. Авдаран сум.
4. Цэрэндорж. Нас 18, эцэг Банди, эх Должин. Ханги сум
5. Сономжав. Нас 15, эцэг Жамц, эх Дашжав. Өндөрсант сум
6. Лхамсүрэн. Нас 16, эцэг Чойжилжав, эх Цэвэл. Сангийн далай сум.
7. Осор. Нас 15, эцэг Хөх-Өчир, эх Лувсанмаа. Цагаан-уул сум
8. Пунцаг. Нас 19, бутач, эх Нойдулам. Шар чулуут сум
9. Пэрэнлэй. Нас 12, бутач, эх Янжинлхам, Есөнзүйл сум
10. Бат-очир. Нас 16, эцэг Чойжилжав, эх Норжин. Өлзийт сум
11. Дэндэв. Нас 14, бутач, эх Цэнд, Оргих сум
12. Бадарч. Нас 11, бутач, эх Балжид. Жаргалант сум.

Ийнхүү орон нутагт байгуулсан сургууль, тэнхимийг өргөжүүлэхэд төр засгаас нилээдгүй анхаарал тавьж байсан бөгөөд 1928 онд тус сургуульд Ц.Дамбадоржийн нэрэмжит пионерийн 46-р бүлгэмийг байгуулж хөвгүүд, охидын дунд төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулан тэдний оюун ухаан болоод бие бялдарыг хөгжүүлэхэд анхаарах болжээ. Энэ үед сургагч багшаар Дүнгээ, Зандар нар ажиллаж, 50 төгрөгийн пүнлүүтэй эмч лам ажиллуулж байсан ажээ.

Аймгийн захиргааны зүгээс ч сургуулийг хөгжүүлэхэд анхааран тэнхимийн

сурагчдын суух гэр хэрэгсэл, ус түлшийг хошууны төсвөөс гүйцэтгүүлэн хэрэглүүлж сурах хөвгүүдийн уух цай, хүнсний зүйлд сар тутам 15 лан мөнгө олгож, хүүхэд бүрт сар тутам хонь хошоод цай хугасыг хэрэглүүлж байхыг хошуудын тамгын газарт даалгаж байжээ.

1931 онд Өвөрхангай аймаг байгуулагдахад Зүүн Өлзийт сумын бага сургууль болж байгуулагдан 1939 он хүртэл нүүдлийн зуны сургалтыг явуулж байв. 1933 онд Хооронд гэдэг газар тэнхимийн сургуульд доктор, просрессор Чой Лувсанжав багтан суралцаж Т өмрицн Лувсандоржийн Г омбо гэдэг багшаар анх ном заалгаж байсан гэж Чой Лувсанжав багш дурсамжиндаа өгүүлсэн байдаг.

1939 онд сум гуулинд төвлөрөхөд бага сургууль одоогийн багийн төвийн зүүн дэнж дээр их бага нийлсэн таван байшин, гурван гэтэй, тэдгээрийг тойрсон шургааган хашаатай байжээ. Байшинд нь хичээл сургалтын ажил зохион байгуулж, гэрт сурагчид суудаг байв.

Сумын төв 1959 онд Сангийн далайд шилжин ирэхэд бага сургуулийг Сангийн далайн бага сургууль хэмээн нэрлэх болж, сургууль нэлээд өргөжин 160 орчим сурагчтай, 7 багштайгаар хичээл сургалтын ажлыг явуулж, эрхлэгчээр нь Ёндонгийн Эоров багш ажиллаж байжээ. 1975 онд 8 жилийн сургууль болон өргөжихөд 400 хүүхэдтэй 16 багштай болж, анхны захиралаар Д.Бэхбат үндэс суурийг тавьж хожим нь захиралаар Д.Сэнгээ анхны 8 жилийн сургуулийн төгсөлтийг хийсэн байна.

1976 онд сум Хүйсийн голд нүүн ирж төвлөрөхөд хичээлийн 390-ийн байр, 110 хүүхдийн дотуур байртай, спортын заалтай барилга байгууламж баригдаж ашиглалтанд оруулсан байна.

1994 онд 10 жилийн дунд сургууль байгуулагдаж 675 хүүхэдтэй сургууль болон өргөжиж сургуулийн захиралаар Ц. Амарттүвшин ажиллаж байжээ.

2007 онд боловсролын шинэчлэлийн дагуу 11 жилийн тогтолцоонд шилжсэн. Энэ үеийн захиралаар Б.Лэгшид ажиллаж байсан.

Мөн 2012 онд боловсролын шинэчлэлийн дагуу 12 жилийн тогтолцоонд шилжсэн. Энэ үеийн захиралаар Ц.Энхтуяа одоог хүртэл ажиллаж байна.Одоогоор 50, 65 хүүхдийн 2 дотуур байр, 2 хичээлийн байр, 42 багш ажилтан, 251 суралцагчтайгаар сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. 2022 онд 240 хүүхдийн шинэ сургууль улсын төсвийн 1,3 тербум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдан ашиглалтанд орж хүүхэд суралцах тохилог орчин нөхцөл хангагдсан.

2022.02.